



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

「Сургалт, дадлага зохион байгуулах тухай」

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.2, 13.3.5, 30 дугаар зүйлийн 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны “Сургалт бэлтгэлийг зохион байгуулах тухай” А/309 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын бүтцийн нэгжүүдийн сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтнүүдийн нэгдсэн сургалт, дадлагыг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулсугай.

2. Сургалт, дадлагын удирдамжийг нэгдүгээр, хөтөлбөрийг хоёрдугаар, оролцох бүрэлдэхүүний нэрийг гуравдугаар, шаардагдах зардлын тооцоог дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт, дадлагад шаардагдах 90.500 (ерэн мянга таван зуун) төгрөгийг хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан Тэргүүн дэд дарга (хурандаа Н.Нямхорлоо)-д даалгасугай.

ДАРГА,  
ХУРАНДАА



Ж.ЧҮЛТЭМСҮРЭН

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн  
2/107 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## НЭГДСЭН СУРГАЛТ, ДАДЛАГЫН УДИРДАМЖ

### НЭГ. ЗОРИЛГО

Гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалтын удирдлага, зохион байгуулалт, алба хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах, хууль эрх зүйн мэдлэг, мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

### ХОЁР. ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧИГ

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, "Онцгой байдлын байгууллагын сургалтын бодлого" зэрэг алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэднийг ажлын байранд сургаж дадлагажуулахад баримтлах баримт бичгүүдийг үндэслэн зохион байгуулна.

### ГУРАВ. СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ ГАЗАР, ХУГАЦАА

Сургалт, дадлагыг Нийслэлийн Онцгой байдлын газрын Соёлын төвд 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр зохион байгуулна.

### ДӨРӨВ. СУРГАЛТ, ДАДЛАГАД ХАМРАГДАХ БҮРЭЛДЭХҮҮН

Нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн, Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төвийн сургагч багш, нийслэлийн Аврах анги-105-ын Сургалт, соёл хүмүүжлийн ажил хариуцсан мэргэжилтэн нар хамрагдана.

### ТАВ. СУРГАЛТ, ДАДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Дадлага, сургалтын хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

1. Хууль эрх зүйн чиглэлээр сургалт явуулж алба хаагчдын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх;
2. Сургалт, сурталчилгааны ажлын гүйцэтгэлийн баримт бичиг боловсруулах, тайлан мэдээ гаргах дадлага ажил хийлгэж, алба хаагч бүрт арга зүйн зөвлөмж өгөх;
3. Онцгой байдлын байгууллага, Нийслэлийн Онцгой байдлын газраас 2020 онд дэвшүүлсэн зорилтууд, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалтыг бодитой төлөвлөх, үр дүнтэй хэрэгжүүлэх, алба хаагчдын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, сургалтын шинэлэг арга барилаас суралцах, ажилдаа нэвтрүүлэх талаар ярилцлага явуулах;
4. Сургалт сурталчилгааны ажил арга хэмжээний үр дүнг нэмэгдүүлэх, үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлэх, ажлын хариуцлагыг дээшлүүлэх чиглэлээр үүрэг өгөх.



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 31-ны өдрийн  
А/с/д дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1117155601  
УХА0038 9377073

### СУРГАЛТ, ДАДЛАГЫН ХӨТӨЛБӨР

Зохион байгуулах хугацаа: 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр  
Зохион байгуулах газар: Нийслэлийн Онцгой байдлын газрын Соёлын төвд

д/д	Хичээлийн сэдэв	Хугацаа	Үргэлжлэх хугацаа	Зохион байгуулах албан тушаалтан, хичээл заах багш
1	Бүртгэл	09:30-09.50	20 минут	Дэслэгч Б.Хишигдарь
2	Сургалт, дадлагын зорилго, хөтөлбөрийг танилцуулах	09:50-10:00	10 минут	Дэд хурандаа Б.Чинбат
3	Сургалт, дадлагын нээлт	10:00-10:10	10 минут	НОБГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Н.Нямхорлоо
4	Гамшгаас хамгаалах чиглэлээр 2018-2019 онд шинээр батлагдан гарсан удирдлагын эрх зүйн баримт бичгийн танилцуулга	10:10-10:50	40 минут	Дэд хурандаа Б.Чинбат
5	Цайны завсарлага	10:50-11:00	10 минут	Ахлах ахлагч Э.Хандармаа
6	Төлөвлөлт, гүйцэтгэлийн баримт бичгийг боловсруулах, анхаарах асуудал	11:00-11:30	30 минут	Дэд хурандаа Б.Чинбат
7	Сургалт, сурталчилгааны ажлын мэдээг бүртгэх, нэгтгэх Excel файлын танилцуулга	11:30-12:00	30 минут	Дэд хурандаа Б.Чинбат
8	Дадлага ажлын даалгаврыг танилцуулах	12:00-12:10	10 минут	Дэд хурандаа Б.Чинбат
9	Сургалт сурталчилгааны ажлын өдөр тутмын мэдээг бүртгэх дадлага ажил	12:10-13:00	50 минут	Сургалтанд оролцогчид
10	Үдийн завсарлага	13:00-14:00	60 минут	Сургалтанд оролцогчид
11	Сургалт, сурталчилгааны ажлын сарын тайлан боловсруулах, ажлын мэдээг тайланд тусгах дадлага ажил	14:00-16:00	120 минут	Сургалтанд оролцогчид
12	Дүгнэлт ярилцлага	16:00-16:30	30 минут	ГУСХ-ийн дарга, хурандаа Г.Нэргүй
13	Сургалт, сурталчилгааны ажлыг цаашид зохион байгуулахад анхаарах асуудлын талаар үүрэг өгөх	16:30-17:00	30 минут	НОБГ-ын дарга, хурандаа Ж.Чүлтэмсүрэн

Жич: Сургалтад хамрагдах алба хаагчид өдөр тутмын хувцас /хатуу мөрдөстэй китель/-тай, хувийн бэлтгэлээ хангаж, хүн бүр зөврийн компьютертой ирнэ.

---oOo---



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн  
10/09 дугаар тушаалын гуравдугаар хавсралт



СУРГАЛТ, ДАДЛАГАД ОРОЛЦОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭР

Д/д	Цол	Овог нэр	Байгууллага	Албан тушаал
1	Хурандаа	Н.Нямхорлоо	НОБГ	Гал түймэртэй тэмцэх, гамшгаас урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан тэргүүн дэд дарга
2	Хурандаа	Г.Нэргүй	НОБГ	ГУСХ-ийн дарга
3	Дэд хурандаа	Б.Чинбат	НОБГ	ГУСХ-ийн ахлах мэргэжилтэн
4	Ахмад	Х.Бурмаа	НОБГ	ГУСХ-ийн мэргэжилтэн
5	Дэслэгч	Э.Оргил	НОБГ	ГУСХ-ийн мэргэжилтэн
6	Дэслэгч	Б.Хишигдарь	НОБГ	ГУСХ-ийн мэргэжилтэн
7	Дэслэгч	Ө.Мөнх-Отгон	НОБГ	Захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
8	Ахмад	Б.Даваасүрэн	НАА-105	Сургалт, соёл хүмүүжлийн ажил хариуцсан мэргэжилтэн
9	Ахлах дэслэгч	Б.Солонго	ГХСАЗТ	Сургагч багш
10	Ахмад	С.Баярмаа	БЗДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
11	Ахмад	С.Должинсүрэн	БЗДОБХ	Урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
12	Ахлах дэслэгч	П.Одонтуяа	БНДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
13	Ахлах дэслэгч	С.Өлзийсайхан	БХДОБХ	Гал түймрийн улсын хяналтын байцаагч, ССУСХОНХ асуудал хариуцсан мэргэжилтний үүргийг хавсран гүйцэтгэгч
14	Дэслэгч	У.Мягмарсүх	БГДОБХ	Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
15	Ахлах дэслэгч	Б.Уянга	НДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
16	Ахлах дэслэгч	Х.Алтанзагас	СБДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
17	Ахлах дэслэгч	Д.Алтантуяа	СХДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
18	Ахмад	Х.Батцэцэг	СХДОБХ	Урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
19	Ахмад	Т.Баярмаа	ХУДОБХ	Сургалт, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
20	Ахлах дэслэгч	Ж.Энхтөр	ХУДОБХ	Урьдчилан сэргийлэх, хэвлэл, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
21	Дэслэгч	Ч.Мөнгөнсарнай	ЧДОБХ	Эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын  
2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрийн  
01/07 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



СУРГАЛТ, ДАДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Нийт үнэ /төгрөг/
1	Кофе	ш	42	300	12.600
2	Цайны боов, жигнэмэг	ш	82	800	65.600
3	Нэг удаагийн аяга	ш	82	150	12.300
	Нийт				90.500

---oOo---